

БОРЖИГИН ОВОГТ ГЭНДЭН-ЯРИНПИЛЫН ЭРДЭНЭ-ОЧИРЫН БҮТЭЭЛИЙН ҮНЭ ЦЭН

Д.Ванчигсүрэн

Өөрийгөө магтаж яваагүй, ерөөлөөр өөд татуулах гэж үзээгүй бидний, бас миний дотно анд Гэндэн-Яринпилын Эрдэнэ-Очирын бүтээлийн алтан сан хөмрөгөөс өчүүхэн төдий ч болов уудлан үзэх хувь тохиосон миний бие оюун төгөлдөр эрдэмтэн, дотно андын бүтээлд ойр дөт байсны учир боржигин овгийн бүтээлч хүүг:

- Ухаалаг багш,
- Боловсрол судлаач,
- Шилдэг сурган хүмүүжүүлэгч
- Мэдрэмжтэй нийтлэгч-сэтгүүлч хэмээн

өргөмжлөх зорилгоор энэхүү өгүүллийг багш, сурган хүмүүжүүлэгчид, оюутан залууст толилуулж байна.

Ухаалаг багш

Дундговь аймгийн Говь-Угтаал сумд хичээлийн эрхлэгч, захирал, аймагтаа сургалт заах аргын кабинетын эрхлэгчийн ажлыг арваад жил хийхдээ багш хүний эрхэм нандин чанар болох **нүнжиг, жудаг, мэдрэмж** ямар байдгийг ажил үйлээрээ, олон арван сургаал, нийтлэлээрээ өгүүлж, сайн багш, арга зүйч болохоо харуулсан тул “Дунд ангийн сурагчдад ярих яриа” /1985 он/, “Монгол хэлний хичээлээр сурагчдын мэдлэг чадвар үнэлэх асуудалд” /1900/, “Багшийн хөдөлмөр” /1976 он/, “Ажил мэргэжил хэрхэн сонгуулах вэ?” /1984 он. “Хэцүү хүүхэд тэдэнтэй ажиллах арга барил” /1980 он/, “Хөдөлмөрөөр алдаршсан гавьяа” 1988 он/ зэрэг 60 гаруй ном, өгүүлэл, нийтлэл, бүтээлээр нь бид “сайн багш” хэмээн энэ илтгэлийн оршил хэсгийг нэрлэсэн болно.

Боловсрол судлаач

Г.Эрдэнэ-Очир 1995 онд нийтлүүлсэн “Ерөнхий дидактикийн үндэс” номдоо дидактикийн үндсэн ухагдахуун категориудыг сурах, сургах үйл ажиллагаа, сургалт, боловсрол, хөгжил, төлөвшил, сургалтын технологи, шавь төвтэй сургалт, хөгжүүлэх арга хэмээн томъёолж,... сургалт нь багш, шавь буюу сурах, сургах хоёр талын үйлийн нэгдэл учраас үйл ажиллагааны **зарчим зохион байгуулалтын хэлбэр, арга хэрэглүүрийн** хувьд өвөрмөц онцлогийг агуулж байдаг” хэмээн СХУ-ны бүтцийн бүрэлдэхүүн хэсэг болох сургах зүйн элементийг системчлэн томъёолсон нь өнөөгийн ерөнхий ба тусгай дидактикт баримталж байгаа боловсрол судлалын категори болон багш бэлтгэх

их, дээд сургууль, магистр, докторын сургалтад уншигдсаар байгаа нь сайн боловсрол судлаач, дидактикч болохыг харуулсан баримтын нэг болох учир Г.Эрдэнэ-Очирыг боловсрол судлаач гэж нэрлэх нэг үндэс гэж үзэж байна.

Боловсрол судлаач доктор Г.Эрдэнэ-Очирын бүтээлүүдээ “Ерөнхий дидактикийн үндэс”/1995 он. “Хүмүүжлийн ажилд цогцолбор хандах нь” /19921, “Анги улируулахгүй сургах тухай асуудалд” /1978 он/, “Сургалтын дэвшилтэт арга” /1981 он/, “Хөдөлмөрийн хүмүүжил, мэргэжлийн баримжаа” /1983 он/, “Боловсролын тухай бодолхийлэл буюу хүмүүжил устлаа хэмээх учирлан” 1991 он/ зэрэг ном, эрдэм шинжилгээний өгүүлэлд боловсрол судлалын тухайн үеийн байдалд задлан шинжилгээ хийж, хүүхдийг анги улируулахгүй гарваль шинжид нь тохируулан сургах **хүн төвтэй боловсрол, шавь төвтэй сургалтын** өнөөгийн байдлыг урьдчилан харж, тухайн үеийнхээ боловсролын системийг “...нийгэм, улс төрийн “зулбадас” нь байсан, тийм байхаас өөр аргагүй...” хэмээн томъёолж байсан төдийгүй боловсрол судлалын судалбал зохих, тулгамдсан олон асуудлыг дэвшүүлэн тавьж байсан нь түүний холыг харагч “зөнч” судлаач байсныг бас харуулна.

Сургалтын агуулгыг оновчтой тодорхойлж, нягтруулах улмаар шинжлэх ухаан техникийн мэдээллийн тасралтгүй өсөлт, боловсролын агуулга хоорондын зөрөөг улам бүр багасгах стратеги зорилтын үүднээс авч үзвэл энэхүү сурах бичиг, орчин үеийн дидактикийн асуудлыг илүүц үг хэллэггүй, оновчтой тодорхойлолт, бичвэрээр онолын өндөр түвшинд томъёолсноороо бусад гарын авлага, сурах бичгээс ялгаатай юм. Г.Эрдэнэ-Очир бүхнийг өөрөө тайлбарлах гэж оролдоогүй, уншигчдыг бие даан ажиллах, мэдлэгээ гүнзгийрүүлэх чиг лүү хөтөлж, тэднийг эргэцүүлэн бодож ухаанд сургах оролдлого хийсэн нь хөгжүүлэх сургалтын өнөөгийн хандлага юм. Энэ нь уг бүтээл уншигчдад өөрийн үзэл, бодролоо нээн илэрхийлэх боломж олгосон сайн бүтээл болохын нэг баталгаа болно.

Г.Эрдэнэ-Очирын суурь бүтээлийн нэг болох “Ерөнхий дидактикийн үндэс” номын агуулга нь манай орны багш бэлтгэдэг их, дээд сургууль, коллежийн сургалтын хөтөлбөртэй тохирох бөгөөд

сургалтын орчин үеийн шаардлагыг өөртөө шингээснээрээ онцлог юм. Мэдээллийг бүрэн төгс эзэмшсэн мэргэжилтэн бэлтгэх боломжгүй болсон өнөө үед мэдээлэл-харилцааны технологитой сайн танилцсан, бие даан мэдлэг эзэмших арга барилд оюутныг сургах нь сургалтын үндсэн зорилт болж байна. Энэ зорилтын үүднээс суралцагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилго бүхий сорилго, дадал, эргэцүүлэл, тодруулга, асуулт, даалгавар зэрэг элементүүдийг оновчтой сонгож оруулсан нь ач холбогдолтой шинэлэг зүйл болно.

СХУ, түүний үндсэн салбарын нэг дидактикийн байх, байхгүйн тухай мөхөс, өрөөсгөл ойлголт газар авах болсон өнөө үед түүнийг Гербарт ба Дьюи нарын гэсэн хоёр үндсэн үзэл баримтлалын үндсэн дээр логик нэгдэлд нь авч үзэж, шинжлэх ухааны бодит судлагдахуун бүхий цогц систем болохыг товойлгон тавьсан нь энэ бүтээлийн бас нэг давуу тал болно. Эдгээрийг үндэслэн “хүн” төвтэй боловсрол, “шавь” төвтэй сургалтыг хэрэгжүүлэх үйлст зоримог алхам хийж чадсан дидактикийн шинэлэг бүтээл гэж үзэх үндэстэй байна.

Шилдэг сурган хүмүүжүүлэгч

Г.Эрдэнэ-Очирын бүтээлийн дотор монгол ардын сурган хүмүүжүүлэх зүйг шинжлэх ухаан болгон хөгжүүлэхэд үндэс болсон дараах бүтээлүүд үнэ цэнтэй “Эцэг эхчүүдийн асуултын хариу зөвлөмж” 1977 он/, “Монгол ардын сурган хүмүүжүүлэх зүйн уламжлалаас” /1979 он/ “Хүнээр хүн хийх монгол ухааны сургамж” /1991”, “Монголчуудын хүмүүжлийн онолын сэтгэлгээний хөгжлийн асуудалд” /1992 он/, “Эртний бичгийн уран зохиол дахь сурган хүмүүжүүлэх өв уламжлалаас” /1981, “Ардын сурган хүмүүжүүлэх зүй” /1998 он/ зэрэг 20 гаруй ном, товхимол, нийтлэл, өгүүллээр нь монгол ардын сурган хүмүүжүүлэх ухааны уламжлалыг цогц шинжлэх ухаан болгон 1998 онд нийтлүүлжээ. Өвөг дээдсийн алтан сан, оюуны өмчийг хойч үедээ өвлүүлэн үлдээс өөр эрхэм зүйн өнөөгийн бидэнд үгүй. Ялангуяа үлэмжийн чанар төгөлдөр, төгс сайн хүнийг өсгөн бойжуулах, “хүнээр хүн хийх” ард түмнийхээ торгон ухааныг цэгц болгон бичиглэж үлдээх нь өнөөгийн энэ үед бүр чухал юм. Г.Эрдэнэ-Очирын эл бүтэн нь Ч. Балхаажавын бясалган, оюун дүгнэлт хийсэнчлэн хэрэгцээ, үйлдвэрлэл, харилцан шүтэлцлийг тойрон эргэх тасралтгүй үйл явц, хөдөлмөр сэтгэлгээ хоёрын харилцан бие биедээ шилжих нэгдэл, мэдээлэл санамжийн хязгааргүй багтаамжтай агуулга, ухамсартай үйлдлийн хамгийн бүтээлч, өөрчлөгч хүч болох хүнийг монгол аж төрөхийн ухаан, газар зүй, экологи, хүн

ам зүйн онцлогт тохируулан боловсруулж хүмүүн болгох ардын билиг ухааныг хичээнгүйлэн сурвалжилж, нэгэн туурвил бүтээл болгосон онцлогтой. Ялангуяа өрнө, дорнод баримталдаг шинжлэх ухааны “хүнээс гадагш”, “хүн рүү” чиглэсэн философийг зөрчлийн ба нэгдлийн гүн ухаан хэмээн үзээд “нэгдлийн гүн ухаан”-ыг монгол ардын сурган хүмүүжүүлэх зүйн нэгэн парадигм гэж үзсэн нь Г.Эрдэнэ-Очирын номын философи үндэслэл ач оновчтой байсныг батлан харуулна.

Эдүгээгийн хийгээд хойчийн эрхэм мэргэдийн олж үзэх судар бичиг ийнхүү нэгээр нэмэгдсэн нь монгол түмний оюуны өмчийн санд нэгэн дусал болсон нь эргэлзээгүй. Энэ бүтээл хойч үеийнхээ төлөө санаа тавигч хүн бүрийн ширээний ном болж, боловсрол, гэгээрлийн салбарын ажилтан, эцэг эх, багш сурган хүмүүжүүлэгчид, багш бэлтгэдэг их сургууль, коллежийн оюутнуудад өвөрмөц нэгэн сурах бичиг, гарын авлага болно гэдэгт уг номыг ариутган шүүсэн миний бие итгэл төгс байсан ба цаашид ч улам бүр баяжин, монгол угсаатны сурган хүмүүжүүлэх зүйн сурвалж байж, үнэ цэнтэй туурвил хэвээр үлдэн, сурган хүмүүжүүлэгч Г.Эрдэнэ-Очирын мөнхөд дуурьсагдах нэрийн хуудас болно гэдэгт итгэлтэй байна. “Монгол ардын сурган хүмүүжүүлэх зүй” хэмээх энэхүү бүтээл нь ардын сурган хүмүүжүүлэх уламжлалыг нэгэн бүхэл бүтэн тогтолцоот шинжлэх ухаан болгох анхны бүтээл мөн гэж үзэж байна.

Мэдрэмжтэй нийтлэгч-сэтгүүлч

Г.Эрдэнэ-Очирын одоогоор бидний мэдэж байгаа 181 бүтээл, 100 гаруй нийтлэл нь цаг үеийн байдал, нийгмийн аливаа үзэгдлийг хурц тод шүүмжлэн, хамгийн эгзэгтэй талаас нь харуулсан, товч тодорхой үг хэллэгийн сонголт нуршаа биш, ер нь найруулгын хувьд төгөлдөр бүтээлүүд байснаас үзвэл багш сурган хүмүүжүүлэгч, боловсрол судлаач Г.Эрдэнэ-Очир мэдрэмжтэй нийтлэгч сэтгүүлч байх гэсэн дүгнэлтэд хүрэх болно.

Төгсгөлд нь хэлэхэд уран бүтээлийнх нь өв санг хойч үедээ уламжлан үлдээх зорилгоор “Ардын сурган хүмүүжүүлэх зүй” нэртэйгээр хоёр дахь хэвлэлд оруулж, бүтцэд нь “Ерөнхий дидактикийн үндэс” болон зарим бүтээлийг нь оруулж, их, дээд сургуулийн сурах бичиг болгох санал дэвшүүлж байна.